



ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД
Б.НАЙДАЛАА ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.09.23 № 63

Эрчим хүчний салбарын хөдөлмөрийн
аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хүрээнд эрчим хүчний салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчлөл, техник тоног төхөөрөмжийн ашиглалт, найдвартай ажиллагааны талаар дараах асуултыг тавьж байна.

1. Системийн хэмжээнд ашиглалтын хугацаа, норм дууссан нийт хэдэн зуух, турбин, шугам сүлжээ, техник хэрэгсэл байгаа ба эдгээрийн осол аваар гаргах эрсдэлийн талаар;

2. Эрчим хүчний яам болон салбар байгууллагуудын 2026 оны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төсөв, зарцуулалт, гүйцэтгэлийн талаар;

3. 2027 онд эрчим хүчний системийн хэмжээнд техник, тоног төхөөрөмж, шугам сүлжээний шинэчлэл, засвар үйлчилгээ хийх талаарх судалгаа, тооцоолол, шаардагдах төсвийн хэмжээ;

4. 2021-2026 онд эрчим хүчний салбарт гарсан үйлдвэрлэлийн осол, аваарын тоо, тэдгээрийн улмаас амь нас, эрүүл мэндээрээ хохирсон болон мэргэжлээс шалтгаалах өвчлөлтэй болсон ажилтны тоо, ослын шалтгаан, нөхцөл;

5. Эрчим хүчний салбарын ажилтнуудын одоогийн цалин хөлсний өрсөлдөх чадвар ямар түвшинд байгаа, цалин хөлс, урамшууллыг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн шийдвэр, арга хэмжээ, үүний үр дүнд дундаж цалин хөлс ямар түвшинд хүрсэн талаар;

6. 2021-2026 онд эрчим хүчний салбарт ажлаас гарсан хүмүүсийн тоо, ажлаас гарсан шалтгаан, эдгээрээс инженер, техникийн ажилтны тоо, тэдний ажлаас гарсан шалтгаан, хүний нөөцийн дутагдлыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар;

2026000185

7.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26.2-т заасан ХАБЭА-н зардлыг дулаан, эрчим хүчний салбарын байгууллагуудад хуульд заасны дагуу бүрэн төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулсан эсэх, 2027 оны төсөвт шаардлагатай хөрөнгийг бүрэн тусгасан эсэх, үүнтэй холбогдуулан салбарын ХАБЭА, техник, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, найдвартай ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээлэл.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



С.ЭРДЭНЭБАТ

2026000185